



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 5/45

Хэрлэн сум

Ажил хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянмөнх сумын ерөнхий сургуулийн захирал В.Энхжаргал нь 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн жирэмсний болон амаржсаны амралт авсан тул тус сургуулийн багш И.Эрдэнэтогтохыг мөн өдрөөс эхлэн сургуулийн захирал томилогдох хүртэл захирлын үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг сумын Засаг дарга /М.Цэнгэл/-д даалгасугай.

3. В.Энхжаргалтай холбогдох тооцоог хийж, дуусган захирлын ажлыг хавсран гүйцэтгэх И.Эрдэнэтогтоход үндсэн цалингаас 40 хүртэл хувиар тооцож олгохыг сургуулийн нягтлан бодогч /А.Ганцэцэг /-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА